

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	2
2	Аудитын тайлан.....	3
2.1.	Оршил.....	3
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	3
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	3
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	4
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	5
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	5
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	6
2.8.1	Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал	6
2.8.2	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	7
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.10.	Үйл ажиллагааны орлого, зардлын талаарх тайлбар, тодруулга	7
2.11.	Шилэн дансны мэдээлэл	7
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	7
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	7
3	Менежментийн захидал	8
3.1	Худалдан авалттай холбоотой асуудал.....	8
3.1.1	Илрүүлэлт:.....	8
3.1.2	Эрсдэл:	8
3.1.3	Өгсөн зөвлөмж:	8
3.1.4	Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:	8
3.2	Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой асуудал	9
3.2.1	Илрүүлэлт:	9
3.2.2	Эрсдэл:	9
3.2.3	Өгсөн зөвлөмж:	9
3.2.4	Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:	9
3.3	Програм хангамжтай холбоотой	9
3.3.1	Илрүүлэлт:	9
3.3.2	Эрсдэл:	9
3.3.3	Өгсөн зөвлөмж:	9
3.3.4	Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:	9
3.4	Анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой	10
3.4.1	Илрүүлэлт:	10
3.4.2	Эрсдэл:	10
3.4.3	Өгсөн зөвлөмж:	10
3.4.4	Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:	10
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	11
4.1	Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан	11
4.2	Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан	12
4.3	Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан	13
4.4	Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан	14
4.5	Аудит хийсэн Зорилто түвшингийн төлөвлөгөө	15
5.	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	16

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт



РСЦ ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ П.ЭНХБАТ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2019.04.09 № 06/697
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу РСЦ ХХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

РСЦ ХХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар РСЦ ХХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

РСЦ ХХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



2. Аудитын тайлан

2.1. Оршил

РСЦ ХХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг РСЦ ХХК-ийн гүйцэтгэх захирал П.Энхбат Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу РСЦ ХХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

РСЦ ХХК-ийн 2018 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

РСЦ ХХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 12 дугаар сарын 13-наас 2019 оны 3 дугаар сарын 15-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 3 дугаар сарын 25-ний өдөр эцэслэн баталгаажуулж, РСЦ ХХК-д хүргүүлэхээр төлөвлөн, Б энд С аудит ХХК-ийн ахлах аудитор Д.Дашхорлоо, аудитор Д.Заяажаргал, аудиторын туслах Б.Эрдэнэтогтох нар хариуцаж хэрэгжүүлэв.

РСЦ ХХК-ийн 2018 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2019 оны 1 дүгээр сарын 15-ний өдөр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, СТОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

РСЦ ХХК-ийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго: Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн үйлдвэрлэлийн тасралтгүй ажиллагааг хангах, зах зээлийн эрэлт нийлүүлэлтэд тулгуурлаж барилга угсралт, засварын ажил, барилгын материалын үйлдвэрлэл, борлуулалтыг цаг тухай бүр шуурхай чанартай гүйцэтгэн компанийн үндсэн үйл ажиллагааг тогтворжуулж, үйлдвэрлэлийн ашигт ажиллагааг тогтмол өсгөнө.

Үйл ажиллагааны чиглэл: РСЦ ХХК нь үйлдвэрлэлийн барилга байгууламж тоног төхөөрөмж мөн албан өрөөнүүдэд зориулагдсан Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн болон бусад байгууллагын захиалгын дагуу үйлдвэрлэж буй бүтээгдэхүүн, үйлчилгээний чиглэлүүд :

- Барилга засварын үйлчилгээ
- Бетон болон шавар зуурмаг, бетон хийц, төмөр бетон хийцүүд
- Модон хийц болон эдлэлүүд
- Вакуум хийц
- Машин механизмын үйлчилгээ

РСЦ ХХК-ийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

РСЦ ХХК-ийн удирдлага Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Компанийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Татварын ерөнхий хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

РСЦ ХХК-ийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцээгүй байна.

Санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа програм хангамж орос хэлээр бөгөөд монгол хэлрүү хөрвөдөггүй, санхүүгийн тайланг мөнгөн сууриар гаргадаг, зохих журналуудыг бүрэн хөтлөөгүй, харьцсан дансыг харах боломжгүй, мөн НБББББ-т 2010 оноос хойш өөрчлөлт хийгээгүй байна.

РСЦ ХХК-ийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах “шаардлагагүй”. гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

РСЦ ХХК-ийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн ERA орос програм хангамж ашигладаг байна.

РСЦ ХХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт “үр нөлөөтэй” гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад РСЦ ХХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, тодруулгатай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 13 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 5 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогын түвшинг 0.2 хувиар сонгов.

Энэ нь орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлого дансанд эрсдэл дунд гэж үзсэнтэй холбоотой юм

РСЦ ХХК-ийн 2018 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлого 16,317.6 сая төгрөг бөгөөд түүний 0.2 хувь болох 32.6 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 0.2 хувиар тооцсон нь орлогын дансанд эрсдэл дунд гэж үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 13 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 3 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 10 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэн.

Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудлыг хэрхэн ангилж, шийдвэрлэсэн байдлыг энэ тайлангийн 2.13-т нэгтгэсэн байдлаар үзүүлэв.

2.8.1 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(сая төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1		Эрдэнэт үйлдвэртэй байгуулсан хамтын гэрээний дагуу хийгдэж байгаа худалдан авах үйл ажиллагааг түүвэрлэн үзэхэд аж ахуйн нэгж болон хувь хүнээс гэрээний үнийг багасгаж, олон удаагийн давтамжтай худалдан авалт хийдэг, худалдан авч байгаа бараа материалын гэрээний бүрдэл дутуу, тендер зарладаггүй, харьцуулалтын аргыг хэрэгжүүлдэггүй
1	Зөвлөмж өгсөн	1		РСЦ ХХК нь ТУЗ-ын зөвшөөрлөөр бүх үйл ажиллагаа нь зохицуулагддаг, зөвхөн Эрдэнэт үйлдвэрийн захиалгын дагуу, статус нь ХХК-аар тодорхойлогдсон зэргээс шалтгаалан Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, НББ-ийн тухай зэрэг хуулиудыг хэрэгжүүлээгүй бие дааж үйл ажиллагаа явуулах эрх нь хязгаарлагдмал байна.
1	Зөвлөмж өгсөн	1		Санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа програм хангамж орос хэлээр бөгөөд монгол хэлрүү хөрвөдөггүй, санхүүгийн тайланг мөнгөн сууриар гаргадаг, зарим журналуудыг бүрэн хөтлөөгүй, харьцсан дансыг харах боломжгүй мөн НБББББ-т 2010 оноос хойш өөрчлөлт хийгээгүй зэрэг нь "НББ-ийн ил тод, ойлгомжтой бүрэн гүйцэт байх" гэсэн зарчмууд алдагдсан байна.
1	Зөвлөмж өгсөн	1	12.9	Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг санхүүгийн тайланд зардлаар хүлээн зөвшөөрсөн
	Дүн	4	12.9	

2.8.2 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудал байхгүй болно.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх асуудал үгүй болно.

2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

“РСЦ” ХХК нь 2018 оны эдийн засгийн үндсэн зорилтот түвшингийн төлөвлөгөөнд орлого 17,600.0 сая, зардал 16,350.8 сая, ашиг 1,250.0 сая төгрөг байхаар төлөвлөж гүйцэтгэлээр орлого 16,346.1 сая, зардал 14,944.9 сая төгрөгийг зарцуулж 1,401.2 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

РСЦ ХХК нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид РСЦ ХХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

РСЦ ХХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидал АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтэд үндэслэсэн болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь РСЦ ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Худалдан авалттай холбоотой

3.1.1 Илрүүлэлт:

Худалдан авах үйл ажиллагааг түүвэрлэн үзэхэд аж ахуйн нэгж болон хувь хүнээс гэрээний үнийг багасгаж, олон удаагийн давтамжтай шууд худалдан авалт хийдэг, тендер зарладаггүй, харьцуулалтын аргыг хэрэгжүүлдэггүй зэрэг зөрчилүүд байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34.2 “Энэ хуулийн 34.1-д заасан нөхцөлийн дагуу шууд гэрээ байгуулахад захиалагч энэ хуулийн 14-16 дугаар зүйлийн шаардлагыг хангасан, тухайн бараа, ажил, үйлчилгээг гүйцэтгэх чадавхитай нэг, эсхүл түүнээс дээш тооны этгээдтэй хэлэлцээ хийж, техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл, шаардлагыг хамгийн сайн хангасан этгээдтэй энэ хуульд заасны дагуу гэрээ байгуулах бөгөөд хэлэлцээний үед хүрсэн аливаа тохиролцоог гэрээнд тусгана” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.1.2 Эрсдэл:

Холбогдох хуулийн заалт зөрчигдөх, санхүүгийн тайлангийн үнэн зөв, эрх үүрэг батламжийн мэдэгдлүүд зөрчигдөх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг мөрдөж ажиллах

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Хүлээн зөвшөөрсөн

3.2 Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой

3.2.1 Илрүүлэлт:

РСЦ ХХК нь ТУЗ-ын зөвшөөрлөөр зөвхөн Эрдэнэт үйлдвэрийн захиалгын дагуу, бүх үйл ажиллагаа нь зохицуулагддаг, статус нь ХХК-аар тодорхойлогдсон зэргээс шалтгаалан Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, НББ-ийн тухай хуулиудыг хэрэгжүүлээгүй бие дааж үйл ажиллагаа явуулах эрх нь хязгаарлагдмал байна.

3.2.2 Эрсдэл:

Холбогдох хууль тогтоомж зөрчигдөх

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллах

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Хүлээн зөвшөөрөн

3.3 Програм хангамжтай холбоотой

3.3.1 Илрүүлэлт:

Санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа програм хангамж орос хэлээр бөгөөд монгол хэлрүү хөрвөдөггүй, санхүүгийн тайланг мөнгөн сууриар гаргадаг, зарим журналуудыг бүрэн хөтлөөгүй, харьцсан дансыг харах боломжгүй, мөн НБББББ-т 2010 оноос хойш өөрчлөлт хийгээгүй зэрэг нь “НББ-ийн ил тод, ойлгомжтой бүрэн гүйцэт байх” гэсэн зарчмууд алдагдсан байна.

3.3.2 Эрсдэл:

Холбогдох хууль тогтоомж зөрчигдөх

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллах

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Хүлээн зөвшөөрсөн

3.4 Анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой

3.4.1 Илрүүлэлт:

Анхан шатны баримтын бүрдэлгүй 12.9 сая төгрөгийн ажил гүйлгээг санхүүгийн тайланд зардлаар хүлээн зөвшөөрсөн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5-д “Аж ахуйн нэгж, байгууллагын аж ахуйн ажил, гүйлгээ нь аль улсын нутаг дэвсгэрт гарснаас үл хамааран холбогдох анхан шатны баримт, бүртгэлийн маягтыг энэ хуульд заасны дагуу бусад баримт, бүртгэлийн маягттай хамт хадгална” заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.4.2 Эрсдэл:

Холбогдох хууль тогтоомж зөрчигдөх

3.4.3 Өгсөн зөвлөмж:

Холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллах

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 дугаар сарын 3-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Балансын зүйл	2017 оны 12 дугаар сарын 31	2018 оны 12 дугаар сарын 31
A	Б	1	2
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	46,156,234.00	2,435,456,207.97
1.1.2	Дансны авлага	1,387,389,685.00	1,383,170,229.56
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	21,504,768.00	15,351,856.25
1.1.4	Бусад авлага /Эрдэнэт үйлдвэр ХХК/	4,416,786,187.00	3,009,072,488.25
1.1.6	Бараа материал	1,209,682,874.00	1,014,880,220.63
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо		60,916,592.33
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	7,081,519,748.00	7,918,847,594.99
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	2,604,778,737.00	2,851,001,519.13
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,604,778,737.00	2,851,001,519.13
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	9,686,298,485.00	10,769,849,114.12
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	224,072,296.00	305,819,008.18
2.1.1.2	Цалингийн өглөг	237,671,464.00	377,552,116.00
2.1.1.3	Татварын өр	215,785,398.00	281,916,379.72
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	100,088,994.00	-
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	777,618,152.00	965,287,503.90
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	25,026,197.00	37,182,982.11
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	25,026,197.00	37,182,982.11
2.2	Өр төлбөрийн нийт дүн	802,644,349.00	1,002,470,486.01
2.3	ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
2.3.1	Өмч: а) төрийн "Эрдэнэт үйлдвэр" ХХК	5,593,680,176.00	5,593,680,176.00
2.3.2	б) хувийн		
2.3.3	в) хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	106,634,052.00	106,634,051.95
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	308,492.00	308,492.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	3,183,031,416.00	4,066,755,908.16
2.3.10	Тайлангийн үеийн	961,646,305.00	1,211,490,192.65
2.3.11	Өмнөх үеийн	2,221,385,111.00	2,855,265,715.51
2.3.20	Эзэмшигчдийн өмчийн дүн	8,883,654,136.00	9,767,378,628.11
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН	9,686,298,485.00	10,769,849,114.12

4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	12,784,953,214.00	16,242,017,798.18
2	Борлуулалтын өртөг	10,374,183,044.00	12,928,336,751.01
3	Нийт ашиг (алдагдал)	2,410,770,170.00	3,313,681,047.17
4	Түрээсийн орлого	-	
5	Хүүний орлого	11,144,123.00	21,387,270.55
6	Ногдол ашгийн орлого	-	
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	
8	Бусад орлого	105,455.00	54,223,065.26
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	
10	Ерөнхий ба удирдлагын зардал	927,668,657.00	1,026,103,010.13
11	Санхүүгийн зардал	-	
12	Бусад зардал	438,185,100.00	997,851,667.72
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз(гарз)	17,398,101.00	194,155.96
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз(гарз)	-	35,636,363.64
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз(гарз)	-	
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз(гарз)	-	
17	Бусад ашиг (алдагдал)	-	
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	1,038,767,890.00	1,401,167,224.73
19	Орлогын татварын зардал	77,121,585.00	189,677,032.08
20	Татварын дараах ашиг (алдагдал)	961,646,305.00	1,211,490,192.65
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	961,646,305.00	1,211,490,192.65
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
24	Орлогын нийт дүн	961,646,305.00	1,211,490,192.65
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	

4.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2017 оны 11-р сарын 31-ний үлдэгдэл	5,593,680,176.00	106,634,051.95	308,492.00	2,221,385,111.00	7,922,007,830.95
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					-
3	Залруулсан үлдэгдэл	5,593,680,176.00	106,634,051.95	308,492.00	2,221,385,111.00	7,922,007,830.95
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				961,646,305.00	961,646,305.00
5	Бусад дэлгэрэнгүй орлого					-
6	Өмчид гарсан өөрчлөлт					-
7	Зарласан ногдол ашиг			-		-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					-
1	2018 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	5,593,680,176.00	106,634,051.95	308,492.00	3,183,031,416.00	8,883,654,135.95
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					-
3	Залруулсан үлдэгдэл	5,593,680,176.00	106,634,051.95	308,492.00	3,183,031,416.00	8,883,654,135.95
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				1,211,490,192.65	1,211,490,192.65
5	Бусад дэлгэрэнгүй орлого					-
6	Өмчид гарсан өөрчлөлт					-
7	Зарласан ногдол ашиг				- 327,765,700.49	- 327,765,700.49
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					-
9	2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	5,593,680,176.00	106,634,051.95	308,492.00	4,066,755,908.16	9,767,378,628.11

4.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	10,505,823,500.00	18,932,643,171.00
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	10,100,849,779.00	18,553,190,880.00
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	97,112,968.00	116,912,291.00
	Буцаан авсан албан татвар		
	Татаас, санхүүжилтийн орлого	307,860,753.00	261,630,000.00
	Бусад мөнгөн орлого		910,000.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	11,291,693,468.00	16,020,678,823.59
	Ажиллагчдад төлсөн	3,542,729,838.00	4,855,698,157.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	960,686,477.00	1,348,634,521.00
	Бараа материал худалдан авахад төлсөн	5,916,275,384.00	8,099,008,555.59
	Ашиглалтын зардалд төлсөн		540,000.00
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	40,420,268.00	143,530,250.00
	Хүүний төлбөрт төлсөн		
	Татварын байгууллагад төлсөн	817,208,250.00	1,556,835,586.00
	Даатгалын төлбөрт төлсөн	14,373,251.00	16,431,754.00
	Бусад мөнгөн зарлага		
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(785,869,968.00)	2,911,964,347.41
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	(198,611,042.00)	(522,858,529.45)
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	11,144,123.00	60,587,270.55
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		39,200,000.00
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
	Хүлээн авсан хүүний орлого	11,144,123.00	21,387,270.55
	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	209,755,165.00	583,445,800.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	209,755,165.00	583,445,800.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(198,611,042.00)	(522,858,529.45)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)		
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
	Төлсөн ногдол ашиг		
3.3	Санхүүгийн үйл ажилгааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
	Валютын ханшийн зөрүү	(17,330,247.00)	194,155.96
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(1,001,811,257.00)	2,389,299,973.92
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,047,967,491.00	46,156,234.00
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	46,156,234.00	2,435,456,207.97

4.5 Аудит хийсэн орлого ба зардлын төлөвлөгөө

(мянган төгрөгөөр)

№	Үндсэн үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2018 оны төлөвлөгөө	2018 оны төлөвлөгөө /тодотгосон/	Зөрүү /+,-/
А	1	2	3	4	5
	Барилга угсралт, засварын ажил	мян.төг	12,238,773.0	16,815,300.0	4,576,527.0
	Бэлэн бүтээгдэхүүн, бүгд	мян.төг	697,000.0	697,000.0	
	Бусад орлого	мян.төг	88,500.0	88,500.0	
3	Нийт орлого	мян.төг	13,024,273.0	17,600,800.0	4,576,527
4	Үйлдвэрийн зардал	мян.төг	10,506,909.0	14,373,750.0	3,866,841
5	Удирдлагын зардал	мян.төг	986,252.0	1,053,589.0	67,337
6	Ашиглалтын зардал	мян.төг	203,965.0	300,665.0	96,700
7	Нийгмийн бусад зардал	мян.төг	622,796.0	622,796.0	0
8	Бүгд зардал	мян.төг	12,319,922.0	16,350,800.0	4,030,878
9	Хамтын гэрээний дагуу ГОК-оос олгосон нийгмийн зардал, бүгд:	мян.төг	652,961.0	652,961.0	
	Бүгд борлуулалтын ашиг	мян.төг	704,351.0	1,250,000.0	545,649
	Балансын ашиг	мян.төг	704,351.0	1,250,000.0	545,649

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:

Аудитын
нэр:**РСЦ ХХК-ийн 2018 оны жилийн эцсийн
санхүүгийн тайланд хийсэн аудит**

Аудитын код:

2019.03.25

САГ-2019/64/СТА-ТӨҮГ

Шалгагдсан байгууллагын нэр:

РСЦ ХХК

сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Худалдан авах үйл ажиллагааг түүвэрлэн үзэхэд аж ахуйн нэгж болон хувь хүнээс гэрээний үнийг багасгаж, олон удаагийн давтамжтай шууд худалдан авалт хийдэг, тендер зарладаггүй, харьцуулалтын аргыг хэрэгжүүлдэггүй	0	Зөвлөмж өгөх	Гүйцэтгэх захирал	П.Энхбат
2	ТУЗ-ын зөвшөөрлөөр зөвхөн Эрдэнэт үйлдвэрийн захиалгын дагуу, бүх үйл ажиллагаа нь зохицуулагддаг, статус нь ХХК-аар тодорхойлогдсон зэргээс шалтгаалан Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, НББ-ийн тухай хуулиудыг хэрэгжүүлээгүй бие дааж үйл ажиллагаа явуулах эрх нь хязгаарлагдмал	0	Зөвлөмж өгөх	Гүйцэтгэх захирал	П.Энхбат
3	Санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа програм хангамж орос хэлээр бөгөөд монгол хэлрүү хөрвөдөггүй, санхүүгийн тайланг мөнгөн сууриар гаргадаг, зарим журналуудыг бүрэн хөтлөөгүй, харьцсан дансыг харах боломжгүй, мөн НБББББ-т 2010 оноос хойш өөрчлөлт хийгээгүй зэрэг нь “НББ-ийн ил тод, ойлгомжтой бүрэн гүйцэт байх” гэсэн зарчмууд алдагдсан	0	Зөвлөмж өгөх	Гүйцэтгэх захирал, Нягтлан бодогч	П.Энхбат Б.Батзаяа
4	Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг санхүүгийн тайланд зардлаар хүлээн зөвшөөрсөн	12.9	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Б.Батзаяа
	Дүн	12.9			

[illegible]

This image shows a full page of a handwriting practice worksheet. It consists of approximately 20 horizontal rows. Each row is defined by two parallel dotted lines, creating a series of uniform gaps for letter height. The entire page is otherwise blank, with no margins, text, or other markings.